

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/113/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
2024 он	Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Аудитор: Р.Баярмаа Утас: 99265539 Цахим хаяг: bayarmaar@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага.....	16
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgii@audit.gov.mn	БУГАТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Б.ЖАНДАУЛЕТ ТАНАА
2024.02.20 № 147 танай _____-ны № _____-т	
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Асуудлыг онцолсон хэсэг	
<p>Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.</p>	
Аудитын гол асуудал	
<p>-Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.</p>	
Бусад асуудлын хэсэг	
<p>Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.</p>	
00402218	

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ж.АЙГҮЛ



Бугат сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	195,842,969.68	278,780,449.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	48,467,860.00	142,436,958.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	48,467,860.00	142,436,958.00
3121	Төгрөг	48,467,860.00	142,436,958.00
31211	Төрийн сангийн харилцах	48,467,860.00	142,436,958.00
33	АВЛАГА	18,277,244.68	9,904,518.20
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	8,406,504.68	9,904,518.20
33300	Татаас, санхүүжилтийн авлага	9,870,740.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	129,097,865.00	126,438,973.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	648,498.00	-
354	Хангамжийн материал	128,449,367.00	126,438,973.00
35420	Аж ахуйн материал	102,718,941.00	95,135,147.00
35430	Сэлбэг хэрэгсэл	101,200.00	-
35440	Түлш, шатах тослох материал	78,960.00	49,000.00
35450	Барилгын засварын материал	2,150,500.00	115,000.00
35460	Хүнсний материал	9,334,266.00	13,939,426.00
35470	Бусад хангамжийн материал	14,065,500.00	17,200,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,387,833,450.80	1,411,413,698.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,387,833,450.80	1,411,413,698.97
392	Биет хөрөнгө	1,347,833,450.80	1,369,990,459.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,386,654,320.55	1,458,854,320.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	(236,079,166.08)	(300,392,794.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	196,405,891.40	238,157,491.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(81,755,971.66)	(107,853,265.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	123,785,914.71	139,858,914.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	(76,383,893.00)	(91,680,561.77)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,800,000.00	11,800,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,000,000.12)	(8,360,000.16)
39217	Ном	29,406,355.00	29,606,355.00
393	Биет бус хөрөнгө	40,000,000.00	41,423,239.00
39301	Програм хангамж	550,000.00	1,973,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	40,000,000.00	40,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,583,676,420.48	1,690,194,148.17
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,870,740.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,870,740.00	-
413	Өглөг	9,870,740.00	-
4136	Бусад өглөг	9,870,740.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	9,870,740.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,573,805,680.48	1,690,194,148.17
51	Засгийн газрын хувь оролцоо	1,573,805,680.48	1,690,194,148.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	476,976,577.00	476,976,577.00
51101	Өмч: - төрийн	476,976,577.00	476,976,577.00
512	Хуримтлагдсан үр дүн	93,395,766.43	209,784,234.12
51210	Өмнөх үеийн үр дүн	93,395,766.43	93,395,766.43

Бугат сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51220	Тайлант үеийн үр дүн	-	116,388,467.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,003,433,337.05	1,003,433,337.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,583,676,420.48	1,690,194,148.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,673,841,059.74	2,012,916,299.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,472,136.40	94,271,639.00
120	Нийтлэг татварын бус орлого	41,472,136.40	94,271,639.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	41,472,136.40	94,271,639.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,632,368,923.34	1,918,644,660.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,418,743,047.00	1,764,455,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,363,048,900.00	1,764,455,400.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	55,694,147.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,570,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,570,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	212,055,876.34	154,189,260.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	212,055,876.34	154,189,260.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,558,317,887.72	1,896,527,831.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,558,317,887.72	1,896,527,831.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,519,914,035.38	1,849,188,427.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	937,564,916.04	1,160,562,536.48
210101	Үндсэн цалин	855,524,797.88	1,157,870,546.48
210102	Нэмэгдэл	82,040,118.16	2,191,990.00
210104	Урамшуулал	-	500,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	253,112,506.12	307,269,193.00
210201	Тэтгэврийн даатгал	253,112,506.12	307,269,193.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136,984,638.34	152,156,848.00
210301	Гэрэл, цахилгаан	4,531,478.34	4,954,559.00
210302	Түлш, халаалт	132,205,160.00	146,773,289.00
210303	Цэвэр, бохир ус	248,000.00	429,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	551,221.66	60,000.00
210401	Бичиг хэрэг	551,221.66	60,000.00
2105	Нормативт зардал	66,669,140.00	66,849,840.00
210502	Хоол, хүнс	66,669,140.00	66,804,840.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	45,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,425,300.00
210604	Урсгал засвар	-	1,425,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,141,100.00	7,264,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,141,100.00	7,264,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,890,513.22	153,600,709.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,817,600.00	25,195,590.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,185,901.00	20,337,529.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	88,887,012.22	108,067,590.83

Бугат сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,403,852.34	47,339,404.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,309,460.00	47,339,363.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,521,500.00	38,618,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,787,960.00	8,721,363.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	94,392.34	41.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	94,392.34	41.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	115,523,172.02	116,388,467.69
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	115,523,172.02	116,388,467.69

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,576,674,776.34	1,928,515,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,576,674,776.34	1,928,515,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,363,048,900.00	1,764,455,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,363,048,900.00	1,764,455,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,570,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,570,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	212,055,876.34	164,060,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	212,055,876.34	164,060,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,481,908,816.34	1,797,170,102.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,481,908,816.34	1,797,170,102.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,436,803,024.00	1,742,214,161.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,063,300,624.00	1,295,451,454.00
210101	Үндсэн цалин	801,159,051.00	889,863,175.00
210102	Нэмэгдэл	215,756,967.00	322,177,064.00
210104	Урамшуулал	46,384,606.00	83,411,215.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,123,400.00	169,455,300.00
210201	Тэтгэврийн даатгал	87,986,600.00	115,229,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,556,800.00	13,556,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,404,700.00	10,845,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,106,900.00	2,711,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,068,400.00	27,113,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,832,260.00	164,718,080.00
210301	Гэрэл, цахилгаан	3,450,000.00	4,650,059.00
210302	Түлш, халаалт	134,382,260.00	160,068,021.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	1,570,000.00	-
210401	Бичиг хэрэг	1,570,000.00	
2105	Нормативт зардал	64,415,540.00	64,727,500.00
210502	Хоол, хүнс	64,415,540.00	64,727,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	600,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	600,000.00	1,100,000.00

Бугат сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,141,100.00	7,414,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,141,100.00	7,414,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,820,100.00	39,347,827.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,127,400.00	28,201,227.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,692,700.00	11,146,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,105,792.34	54,955,941.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,011,400.00	54,955,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,247,000.00	45,265,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,764,400.00	9,690,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	94,392.34	41.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	94,392.34	41.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	94,765,960.00	131,345,298.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	46,298,100.00	37,376,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,298,100.00	37,376,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	46,298,100.00	37,376,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	46,298,100.00	37,376,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(46,298,100.00)	(37,376,200.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	48,467,860.00	93,969,098.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		48,467,860.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	48,467,860.00	142,436,958.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	476,976,577.00	1,003,433,337.05	-22,127,405.59	1,458,282,508.47
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	476,976,577.00	1,003,433,337.05	-22,127,405.59	1,458,282,508.46
C07	Тайлант үеийн үр дүн			115,523,172.02	115,523,172.02
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	476,976,577.00	1,003,433,337.05	93,395,766.43	1,573,805,680.48
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	476,976,577.00	1,003,433,337.05	93,395,766.43	1,573,805,680.48
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	476,976,577.00	1,003,433,337.05	93,395,766.43	1,573,805,680.48
D08	Тайлант үеийн үр дүн			116,388,467.69	116,388,467.69
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	476,976,577.00	1,003,433,337.05	209,784,234.12	1,690,194,148.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Бугат сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,968,033,300.00	1,834,546,261.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,968,033,300.00	1,834,546,261.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,906,173,600.00	1,779,590,361.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,384,712,700.00	1,295,451,454.00
210101	Үндсэн цалин	941,580,700.00	889,863,175.00
210102	Нэмэгдэл	359,991,700.00	322,177,064.00
210104	Урамшуулал	83,140,300.00	83,411,215.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	173,089,400.00	169,455,300.00
210201	Тэтгэврийн даатгал	117,701,100.00	115,229,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,847,100.00	13,556,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,077,600.00	10,845,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,769,300.00	2,711,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	27,694,300.00	27,113,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	164,260,000.00	164,718,080.00
210301	Гэрэл, цахилгаан	4,650,000.00	4,650,059.00
210302	Түлш, халаалт	158,310,000.00	160,068,021.00
210303	Цэвэр, бохир ус	1,300,000.00	
2105	Нормативт зардал	91,302,800.00	64,727,500.00
210502	Хоол, хүнс	91,302,800.00	64,727,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,954,200.00	7,614,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,454,200.00	7,614,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,754,500.00	76,524,027.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,573,300.00	65,377,427.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,181,200.00	11,146,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,859,700.00	54,955,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,859,700.00	54,955,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,690,400.00	9,690,400.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,968,033,300.00	1,928,515,359.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,764,455,400.00	1,764,455,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,764,455,400.00	1,764,455,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	165,360,000.00	164,059,959.00
132001	Орон нутгийн төсвөөс	165,360,000.00	164,059,959.00

Бугат сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	38,217,900.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,500,000.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	35,717,900.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		48,467,860.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		142,436,958.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	81	79
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	50	49
620003	Үйлчлэх ажилтан	29	28
620004	Гэрээт ажилтан	1	1
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	-	-
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	-	-
630001	Төрийн өмчит ЕБС	450	436
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1	1
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	51	50
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	28	27
650010	Гэрээт ажилтан	1	1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Нэмэлт төсөв аваагүй.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль нь ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль 2023 онд "Багш бүр тасралтгүй хөгжиж, суралцагчдын асран хамгаалагч нартай хамтран ажиллаж, хүүхдүүдийн хүмүүжил, төлөвшил, мэдлэг чадварыг сайжруулан ахиц гаргах" эрхэм зорилгын хүрээнд хэрэгжүүлэх нийт 9 зорилт, 91 төрлийн арга хэмжээг төлөвлөж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар "Хөтөлбөр батлах тухай" тушаалаар аккрузал суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Сургуулийн 2020-2022 оны үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба төлөвлөгөөт шалгалт хийсэн байна.

Сургууль нь дотоод хяналтын нэгжгүй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2020 оны А/28 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 106.1 сая төгрөгөөр буюу 6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	48467.86	142436.96	93969.10
Авлага	18277.24	9441.86	-8835.39
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	129097.87	126438.97	-2658.89
Үндсэн хөрөнгө	1387833.45	1411413.70	23580.25
Нийт хөрөнгө	<u>1583676.42</u>	<u>1689731.49</u>	<u>106055.07</u>
Өр төлбөр	9870.74	0.00	-9870.74
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1573805.68	1689731.49	115925.81
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>1583676.42</u>	<u>1689731.49</u>	<u>106055.07</u>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 142.4 сая төгрөг болж 93.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 91.1 сая, , хоолны зардлаас 26.6 сая, бараа үйлчилгээний бусад зардлаас 5.1 сая, үдийн хоолны зардлаас 6.9 сая, өмнөх оны үлдэгдэл 12.8 сая, нийт 142.4 сая төгрөг байна.

Авлага дансанд оны эхэнд 18.3 сая төгрөгийн ажиллагсдаас авах авлагатай байснаас 9.8 сая төгрөг нь орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийн авлага, 2.9 сая төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, 5.6 сая төгрөг нь ажиллагсадтай холбоотой авлага байна. Оны эцэст 9.4 сая төгрөгийн авлагатай байна. Үүний 3.0 сая төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, 0.8 сая төгрөг нь хувь хүний орлогын албан татварын авлага, 5.6 сая төгрөг нь ажиллагсадтай холбоотой авлага байна. Ажиллагсадтай холбоотой авлагын насжилт 7-8 жил байна.

Бугат сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа материал данс оны эцэст 126.4 сая төгрөг болж оны эхнээс 2.7 сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн хөрөнгөөр 296.7 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна. Оны эцэст 95.1 сая төгрөгийн аж ахуйн бараа материал, түлш шатах, тослох материалын 0.0.04 сая, барилгын бусад хангамжийн 17.2 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,411.4 сая төгрөг болж 23.6 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 37.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй 94.5 төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

Өр төлбөр дансанд оны эхэнд 9.8 сая төгрөгийн байгууллагад төлөх бусад зардлын тооцооны өглөгтэй байсныг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 115.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 115.9 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөв 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,020.6 сая, орон нутгийн төсвөөс 164.1 сая, нийт зарлагыг 2,184.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 125.7 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 18.2 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 44.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нормативт зардлыг 50.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 15.7 сая, бусад урсгал шилжүүлгийг 379.6 сая төгрөгөөр тус тус бууруулж, төсвийн төсөлд хүргүүлсэн дүнгээс нийт 256.9 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйтэй холбоотой байна.

Тус байгууллагын 2023 оны анх батлагдсан төсөв 1,927.9 сая төгрөг байна. Үүнд: Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,725.4 сая, орон нутгийн төсвөөс 164.1 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2.5 сая, урьд оны үлдэгдлээс 35.7 сая, нийт 1,927.9 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны анх батлагдсан төсвийг 40.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,968.0 сая төгрөгөөр тодотгож баталсан байна

Анх батлагдсан төсвөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 29.1 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 3.6 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 1.1 сая, урсгал шилжүүлгийг 6.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тодотгосон байна.

Төрийн албан хаагчдын цалин 2023 онд үнэмлэхүй хэмжээгээр нэмэгдсэнтэй холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлуудыг нэмэгдүүлж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,968.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 165.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2.5 сая төгрөгийг

Бугат сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

үндсэн үйл ажиллагааны орлогоос, 35.7 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,764.4 сая, орон нутгийн төсвөөс 164.1 сая, нийт 1,928.5 сая төгрөгийн төсвөөр үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,834.5 сая төгрөг буюу 93.2 хувьтай, дансанд 142.2 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Ерөнхий боловсрол				
1	Байр ашиглалтын үйлчилгээ	2,981.70	2,964.18	-17.52	99.41%
2	Сургалт семинар	1,490.80	1,305.40	-185.40	87.56%
3	Эрүүл мэндийг дэмжих	2,981.70	1,469.40	-1,512.30	49.28%
4	Үдийн цай хөтөлбөр	52,169.30	45,265.50	-6,903.80	86.77%
5	Дотуур байрны үйлчилгээ	153,795.30	121,021.10	-32,774.20	78.69%
6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	39,181.70	36,718.20	-2,463.50	93.71%
7	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	6,708.70	6,206.00	-502.70	92.51%
8	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	8,050.00	8,050.00	0.00	100.00%
9	Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр	1,105,459.40	1,033,465.77	-71,993.63	93.49%
10	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	427,354.70	414,020.76	-13,333.95	96.88%
11	Сурах бичгийн түрээс	2,500.00	0.00	-2,500.00	0.00%
12	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	165,360.00	164,059.96	-1,300.04	99.21%
	Дүн	1,968,033.30	1,834,546.26	-133,487.04	93.22%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 296.7 сая төгрөгийн бараа материал, 37.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бугат сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Баярмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,558.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 15.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шалгахаар төлөвлөсөн 30 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлж, хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Бугат сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувь, хугацаа хоцролтын хэрэгжилт 78.4 хувь байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлүүд холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 37.8 сая төгрөгийн алдаа¹ илэрч залруулсан. Үүнд:

Санхүүгийн байдлын тайланд хувь хүний орлогын албан татварын 0.5 сая төгрөгийн авлагыг тайлагнаагүй, Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлыг 37.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан, Төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн төсвийн санхүүжилтээс төвлөрүүлэх шилжүүлэг 41 төгрөгийг цэвэрлээгүй тайлагнасан алдаануудыг залруулав.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Бугат сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 23.2 сая төгрөгийн зөрчил² илэрч, 0.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 23.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 0.1 сая төгрөгийн зөрчилд акт тогтоосон.Үүнд:

Нэг ажилтан олгосон цалингийн урьдчилгаанаас 0.1 сая төгрөгийг дутуу суутгаж, авлагаар бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ” , 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага ” заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Цалингийн зардлаас ажилтнуудад 23.1 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ХХОАТ-ын илүү төлөлтийг авлагаар тайлагнаагүй	1	462.7	1	462.7			1	462.7				
Биет бус хөрөнгө худалдан авах зардлыг үйл ажиллагааны зардлаар тайлагнасан	1	37,376.2			1	37,376.2	1	37,376.2				
ТГТ-д төвлөрүүлэх шилжүүлгийг цэвэрлээгүй тайлагнасан	1	41			1	41	1	41				
Дүн	3	37,838.9	1	462.7	2	37,376.24	3	37,838.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	23,100.0					1	23,100.0				
Удчилгааг дутуу суутгасан	1	100.0	1	100.0								
Дүн	2	23,200.0	1	100.0			1	23,100.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Бугат сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								